

**АРДЫН ХУВЬСГАЛЫН ДАРААХ БНМАУ-ЫН
ТҮҮХИЙН ТОЙМ (1949-1985)****Н.Ишжамц.** ШУА-ийн сурвалжлагч гишүүн

Империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгал Хятадад ялсны ачаар 1949 оны 10-р сарын 1-нд БНХАУ байгуулагдаж, Хятад орон, Хятадын ард түмэн социализмын замаар хөгжих бололцоотой болсон юм. БНХАУ-д ХКН-ын удирдлагын Мао Цзедун, Лю Шаоци, Чжоу Энълай нар тэргүүтэй шинэ ардын ардчилсан төр, ардын засгийн газар байгуулагджээ.

Чан Кайши тэргүүтэй гоминьданы баруун жигүүрийн харгис этгээдүүд Тайваньд зугтан очиж Америкийн империализмд түшиглэсэн тоглоомын засгийн газар байгуулж, эх газрын Хятадын эсрэг элдэв аргаар дайсагнах болсон байна. ЗХУ зэрэг социалист, ардын ардчилсан орнууд БНХАУ-ыг тэр даруй зөвшөөрөн хүлээж асар их дэмжлэг тусламж үзүүлсэн бөгөөд удалгүй Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнууд болон зарим хөрөнгөтөн улс түүнтэй дипломат харилцаа тогтоосон байна.

1950 оны 2-р сард ЗХУ Хятадтай найрамдал, харилцаа холбоо, харилцан туслалцах гэрээ байгуулсан явдал БНМАУ-ын цаашдын хөгжилд туйлын чухал ач холбогдолтой болсон юм.

1949 оны эцсээс 1952 оны үест ХКН нь дайнд сүйрсэн тус орны эдийн засгийг сэргээн босгох үйл хэрэгт ард түмнээ удирдан жолоодсон юм. Зөвлөлтийн Засгийн газар Хятад орны эдийн засгийг сэргээн босгож хөгжүүлэхэд эхний ээлжинд 300 сая америк долларын зээлийн тусламж үзүүлжээ. 1952 онд зөвлөлтийн Засгийн газар Хятад Чаньчүний төмөр зам, Порт-Артурыг шилжүүлэн өгчээ. Улсын мэдэлд шилжүүлсэн томоохон үйлдвэр, аж ахуйн газрууд зөвлөлтийн тусламжаар барьж байгуулсан, шинэчлэн засаж сэлбэсэн 50-иад аж ахуйн газруудаас бүрдсэн улсын социалист сектор хятадын эдийн засагт шинээр бий болсон байна. Улсын социалист, хагас социалист секторын хувийн жин 1949 оны эцсээр 36.7% байсан нь 1952 онд 61% хүртэл өсөн нэмэгдэв. Газрыг улсын өмч болгож, газрын эздийн газрыг ядуу, дунд тариачдад хуваан өгч, газрын шинэчлэл хийж, хөдөө тосгонд хамтын аж ахуйн хоршооллын эх үүсвэрийг бий болгожээ. 1951-1952 оны үест тариачдын 40 шахам хувь нь харилцан туслалцах хөдөлмөрийн группүүдэд орж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 3600 хоршоолол байгуулагдаад байв. Аж үйлдвэрийн үйлдвэрлэл дайны өмнөх үеийнхээс 22%-иар давж, үр тарианы хураалт 164 сая тонн болж, дайны өмнөх хамгийн дээд хэмжээнээс хэтэрчээ. 1952 оны эцэст ардын аж ахуйг сэргээн босгох зорилт биелсэн байна.

1953-1957 оны үест БНХАУ, Хятадын ард түмэн нь ХКН-ын удирдлага, социалист бусад орны тусламжтайгаар социализмын үндэс суурийг тавих зориулгатай, улс, ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлэн биелүүлэв. Аж үйлдвэр жилд дунджаар 19.2%-иар хурдацтай хөгжиж, таван жилийн төлөвлөгөөг 21%-иар давуулан биелүүлжээ. БНХАУ-д нисэх онгоц, автомашин, суурь машины үйлдвэр, химийн ба техник хэрэгслийн үйлдвэр зэрэг аж үйлдвэрийн чухал шинэ салбарууд бий болж хөгжив. Нийтдээ 428 томоохон үйлдвэрийн газрыг шинээр барьж байгуулан, 109-ийг үндсэнд нь барьж дуусгасан байна. ЗХУ Хятадад үйлдвэрийн 161 томоохон газрыг барьж байгуулах, засаж сэлбэхэд бүх талын тусалцаа үзүүлжээ. Тэр зорилгоор ЗХУ Хятадад 520 сая рублийн удаан хугацааны зээл олгож, 3 миллиард рублийн тоног төхөөрөмжийг эд бараа солилцох журмаар олгосон байна. Нэгэнт 1956 онд Хятадын аж үйлдвэрийн 91.7% нь социалист секторын бүрэлдүүнд хамаарагдаж, хөдөө аж ахуйн 96.3% нь хоршоололд нэгтгэгдсэн байв. Ажилчин, албан хаагчдын цалин 42%, тариачдын орлого 30%-иар нэмэгдэж, ард түмний аж амьдрал, ахуй байдал сайжирч байв.

1957 онд социалист үйлдвэрлэлийн харилцаа ялж, социализмын эдийн засгийн суурь үндсэндээ тавигджээ.

Америкийн империализм БНХАУ-ын эсрэг зүсэн бүрийн өдөөн хатгалга хийж, Тайвань дахь гоминданы харгис дэглэмийг дэмжин “хоёр Хятад” гэгч бодлого явуулж, БНХАУ-ыг НҮБ-д хууль ёсны байр сууриа эзлэхэд нь саад хийж байв. Гэвч социалист бүтээн байгуулалтын амжилт, энх тайванч гадаад бодлогын ачаар БНХАУ-ын хүч нөлөө нэр хүнд дээшилж, 1957 онд нэгэнт 29 улстай дипломат харилцаа тогтоож, 68 оронтой худалдаа хийдэг, 101 оронтой соёлын харилцаатай болоод байв.

1956 онд ХКН-ын VIII их хурал хуралдаж, 1958-1962 онд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөний төсөл хэлэлцээд үндэсний орлогыг 50%, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнийг 2 дахин нэмэгдүүлж, үр тариа, хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээг 15 млрд пүүд, гахайн тоо толгойг 250 саяд хүргэх зорилт дэвшүүлэв. ЗХУ-аас Хятадад үзүүлэх тусламжийг нэмэгдүүлж, төмөрлөг, нефть, цахилгаан техник, радиотехник, байшин барилгын үйлдвэр зэрэг 125 үйлдвэрийн газрыг барьж байгуулах, засаж сэлбэхэд туслах, ихээхэн ач холбогдол бүхий техникийн 122 зангилаа асуудлыг шийдвэрлэх, шинжлэх ухаан-техникийн хамтарсан дорвилог шинжилгээ хийхээр хэлэлцэн тохиролцсон байна. Хятадын ард түмэн II таван жилийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж бүрэн чадах байсан бөгөөд цаашид ЗХУ зэрэг социалист бусад улс оронтой хамтын ажиллагааг өргөтгөн бэхжүүлэхийн хирээр БНХАУ нь техник-эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын бүх салбарт улам их амжилт олж, Англи зэрэг өндөр хөгжилтэй зарим хөрөнгөтөн улсыг аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээгээр гүйцээж түрүүлэх боломжтой байв.¹

Гэтэл 1958 онд Мао Цзедун Хятад орныг эдийн засгийн хөгжлийн бодит зүй тогтлын шаардлагын үндсэн дээр тулгуурлан тодорхой эрэмбэ дараалал, товлосон төсөл төлөвлөгөөтэй хөгжүүлж, шинжлэх ухааны социализмыг улс орон даяар тууштай хэрэгжүүлж, шинжлэх ухааны социализмыг улс орон даяар тууштай хэрэгжүүлэх тухай намын жанжин шугам, II таван жилийн төлөвлөгөөний заалтыг дур зоргоор

¹ С.Г.Юрхов: 35 ление Китайской народной революции-“Проблемы дальнего востока” сэтгүүл., № 3. 1984., с 27.

өөрчилж, хөгжлийн хурдцыг эрс нэмэгдүүлэн тавхан жилийн дотор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээг 6.5 дахин өсгөж, ган хайлуулалтын хэмжээг 80-100 сая тоннд хүргэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг 2.5 дахин өсгөх, шууд коммунизмд шилжин орох гэсэн “зүүнтний” хэт гаармал жанжин шугам дэвшүүлж намд тулган хүлээлгэсэн байна.

Тэрээр Хятад даяар “ардын коммун” байгуулж, 3 жилийн дотор “их үсрэлт” хийж, ЗХУ, АНУ зэрэг аж үйлдвэрийн тэргүүний улс гүрнийг гүйцэж түрүүлэх гэсэн үл гүйцэлдэх хэнээрхэлд улс орныг албын хүчээр татан оруулав. Чухам тэр үед Маогийн “жанжин шугам”, “их үсрэлт”, “ардын коммунын” бодлогыг багтаасан” гурван улаан туг”-ийн лоозон гарч иржээ. Маогийн энэ балмад бодлогын уршгаар Хятадын улс аж ахуй хөгжсөнгүй, харин эмх замбараагүй байдал гарч олон талаар ухралтад орсон байна. 1961-1965 онд хооронд тийм байдлыг засах зорилготой “зохицуулах” бодлого явуулсан боловч түүний улс ардын аж ахуй нь 1957 оны хэмжээнээс асар хэтэрсэнгүй.

1966 оноос эхлэн БНХАУ-д Маогийн “Пролетарийн соёлын их хувьсгал” хэмээх улс төрийн томоохон балмад кампани сүржин өрнөв. Тухайн үед үнэн хэрэг дээрээ “гурван улаан туг”-ийн бодлогыг дахин сэргээж, хэрэгжүүлэх гэсэн байдалтай байсан боловч хятадын улс ардын аж ахуй, соёлын хөгжлийн асуудал хойш тавигдаж, ХКН-ыг их гүрний жанжлах дээрэнгүй үзэлт маоист нам болгон өөрчилж, БНХАУ-ыг социалист системээс салган, империалист ертөнцтэй ойртох сүлбэлдэх явдлыг хангах улс төрийн эргэлтийн зорилт голлон тавигдсан байв.

“Соёлын хувьсгал”-ын үед Лю Шаоци, Пэн Дэхуй нарын зэрэг нам, төрийн удирдагчид, яам, тусгай газар, цэрэг, төв, орон нутгийн байгууллага, шинжлэх ухаан, соёл, урлагийн олон зүтгэлтнийг хэлмэгдүүлж, нам төр, цэргийн төв, орон нутгийн бүх байгууллагын удирдлагыг маогийнхан булаан эзэлжээ. Улс орон даяар цэргийн дарангуйлал тогтож, ухамсар мөчид “самуун дэгдээгчид”, учир үл мэдэх залуу, ихэнхдээ бага балчир “улаан хамгаалагчид” Маогийн дохиогоор газар сайгүй дураараа аашилж байв. 1969 онд маогийнхан зөвлөлтийн хил дээр хоёр ч удаа зэвсэгт өдөөн хатгалга хийж, зөвлөлтийн эсрэг үзлийг бүх шугамаар дэвэргэж байв. 1972 онд АНУ-ын ерөнхийлөгч Р.Никсоныг Хятадад ирүүлж айлчлуулан, Америктай ил далд холбоо сүлбээ байгуулаад Японтой мөн дотно харилцаа тогтоох, “найрамдлын” гэрээ байгуулахаар хэлэлцэн тохиролцсон байна. Маогийнхан тухайн үед “хоёр хэт ир гүрэн” ЗХУ, АНУ-ын эсрэг тэмцэх тухай дэлхийн улс түмэнд уриалж байгаад дараа нь ЗХУ-ыг “нэгдүгээр зэргийн дайсан” гэж зарлан АНУ болон бусад бүх улс орон Зөвлөлтийн эсрэг нэгдсэн фронт байгуулж тэмцэхийг уриалж байв. Мао бол социалист систем, улс түмний аюулгүй байдал, энх тайвны асуудлыг зөвшөөрөн хүлээхгүй, дайн байлдаан, ялангуяа халуун цөмийн дайныг хамгийн махруун сурталчлагч болж хувирсан дотор цэрэг-дайны хүчирхэг гүрэн болгож, орчин тойрны улс түмнийг эзэлж, улмаар даян дэлхийд жанжлал тогтоох явдал байжээ. Тэрээр БНМАУ-ыг Хятадтай нэгтгэх тухай асуудлыг нэг биш удаа ил, далдуур хэлбэрээр тавьж байв. Марксизм-ленинизм, пролетарийн интернационализмд харш Маогийн бодлого нь Хятадын нийгэм-эдийн засгийн социалист маягийн суурьтай гүн гүнзгий зөрчилд орж, тус орны доторх хятад ба хятад биш үндэстний угсаатны ард түмнүүдийн

эсэргүүцэл тэмцэл, коммунистууд болон нийт хөдөлмөрчид ард түмний дургүйцэлтэй тулгарсан юм. Хятадын зарим хот тосгон, Төвд, Синьцзян, Өвөр Монгол зэрэг үндэстний районуудад бослого хөдөлгөөн гарч, эсэргүүцлийн жагсаал хийж байв. Хятадын эрдэмтэн сэхээтэн нар маогийн бодлого, “гурван улаан туг”-ийн лоозон, “соёлын хувьсгал” зэргийг далдаар ёгтлон эсэргүүцсэн зохиол, жүжиг, өгүүлэл бичиж нийтлүүлэн байв. Хятадын зах хязгаар, үндэстний цөөнхийн районуудаас маш олон хүн хил давж, гадаад улс оронд дүрвэн гарч байв. Энэ бүхэн нь Маогийн бодлогыг явцгүй болгож байв.

1976 онд Мао үхэж, “соёлын хувьсгал” эцэс болсон боловч Хятадад түүний учруулсан хор хохирол, үлдээсэн уршиг дагавар нь даанч их байжээ. Маогийн дараа улс төрийн тавцан дээр гарч ирсэн Хуа Гофэн тэргүүтэй Хятадын нам, төрийн удирдлага нь “Мао Цзэдуны үзэл санаа” гэгчийг намын үзэл суртлын үндэс хэвээр байлгаж, маоизмыг улс төрийн бодлого үйл ажиллагаандаа ягштал баримталсаар ирсэн боловч “соёлын хувьсгал”-ын 10 жилийг аж ахуй, эдийн засгийн сүйрлийн 10 жил, үр ашиггүй гарзадсан жилүүд, “феодлын маягийн фашизмын жилүүд гэж албан ёсоор тодорхойлж, түүнээс аль болохоор зааглан салахыг оролдож, Маогийн илт дампуурсан зарим баримтлалыг шүүмжилж, арга тактикийн зарим зүйлийг уян хатан болгожээ.

1978 оны эцэст болсон ХКН-ын Төв хорооны III бүгд хурал, ялангуяа 1982 онд хуралдсан ХКН-ын XII их хурлын үеэс эхлэн Дэн Сяопин, Ху Яобан, Чжао Цзыян нарын зэрэг Бээжингийн шинэ удирдлага нь дотоод бодлогын хувьд эдийн засгийн хөгжлийн бодит зүй тогтол, нийгмийн гишүүдийн материаллаг сонирхол, хүний амьдрал ахуйн хэрэгцээ шаардлагыг эрхбиш анхаарч, гадаад бодлогын хувьд ЗХУ зэрэг социалист орнуудтай хэвийн харилцаа тогтоон, дайны уриа лоозонг огоорч, улс түмний аюулгүй байдал, Ази тив ба даян дэлхийн энх тайвны асуудлыг эрхэмлэх тухай ярих болсон юм.

Нэн түрүүн тэд Маогийн үед хэлмэгдсэн нам, төр, цэрэг, олон нийт, шинжлэх ухаан, соёл урлагийн зүтгэлтэн нарыг цагаатгаж, “соёлын хувьсгал”-ын үед хаагдсан үйлдвэр, аж ахуйн газар, сургууль, соёл, олон нийтийн байгууллагуудыг сэргээж, үндэстний цөөнхийн районуудад зарим сургуулийг нутгийн ард түмний хэл бичиг хэрэглэн сургах зэргийг зөвшөөрсөн байна. Хятадын хөдөө тосгон, хот суурин газруудын аль алинд трактор, комбайн, автомашин зэрэг үйлдвэрлэлийн хэрэгслийг худалдаж, хувийн ба амины өмч болгож байна. 1985 оны эхний улирлын байдлаар хөдөө аж ахуйд байгаа бүх тракторын 68% буюу 2 сая 780 мянга нь зам харилцааны төрөлжсөн ачааны машины тэн хагас (120 мянга) нь амин хувийн өмчид шилжсэн байв. Хөдөө аж ахуйд коммуны бригадын гишүүн бүрд тодорхой тоо хэмжээний үр тариа, мал сүрэг, гахай, тариа зэргийг хариуцуулан өгч улсад тушаах татварыг төлөөд илүү гарсан зүйлийг хариуцуулан өгч ашиглах, зах зээл дээр чөлөөтэй худалдаж борлуулахыг зөвшөөрөн, эдийн засагт үйлдвэрлэлийн хариуцлагын системийг нэвтрүүлэх ажээ. Өнгөрсөн 1984 оноос эхлэн үйлдвэрлэлийн хариуцлагын системийг хотуудад өргөн дэлгэр нэвтрүүлж, хот хөдөөд хувийн өмч, хөлсний хөдөлмөр, зах зээлийн худалдаа, өрсөлдөөн зэргийг зарим талаар чөлөөтэй тавьж, эдийн засгийг сэргээн хөгжүүлэхэд ашиглахаар шийдэв. Ингэж хүний амин хувийн материаллаг сонирхлыг дээшлүүлсний үндсэн дээр аж ахуй, эдийн засагт зарим талын ахиц гарч, олон сая ажилгүйчүүдээс бусад ажил төрөлтэй хүмүүсийн нэлээд хэсгийн

амьдрал урьдынхаас арай дээрдэх төлөвтэй болж байна. Гэвч нийгмийн гишүүдийн нэг хэсэг нь баяжиж, нөгөө хэсэг нь ядууран, ажилгүйчүүдийн эгнээ улам өргөжих байдал төлөв илт ажиглагдаж байна. Хятадын удирдлагын зүгээс ард иргэдээ “баяжигтүн!” гэж уриалж байгаа нь чухамдаа хөрөнгөтний ёсыг сурталчилсан чиглэл бүхий лоозонгийн нэг мөн гэсэн сэтгэгдэл төрүүлж байна.

Хятадын удирдлага нь Америк, Япон, Англи, баруун Герман зэрэг хөрөнгөтөн орнуудын хувьд “нээлттэй хаалгын” бодлого явуулж, зарим хот суурин, муж районуудад, тухайлбал 100 боомт газруудаа хөрөнгөтөн орнуудын капиталыг чөлөөтэй нэвтрүүлээд, Гонконг, Тайванийг эх газартай энх тайвны замаар эргүүлж нэгтгэх, улс орны нэгдмэл байдлыг бүрэн сэргээх эрмэлзэлтэйгээ уялдуулан “нэгэн улс, хоёр систем” гэсэн баримтлал гаргаж, Хятадад социализм байгуулахдаа капитализмыг тодорхой нөхцөлд хослуулан хэрэглэх журмаар хөгжих замд ороод байна. Тийм учир Хятадын засгийн газар нь одоо үед ЗХУ зэрэг социалист бусад оронтой бас эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн ба соёл, урлагийн нэлээд өргөн харилцаа тогтоон ажиллахыг зорих болов.

Энэ бүхэн нь Хятадын онцлог бүхий “Хятад маягийн социализм” гэгчийн мөн чанарын өвөрмөц шинжийг илтгэн харуулж байгаа зүйл юм. Хятадын удирдлага үүнийг онолын үүднээс үндэслэн тайлбарлахдаа, тус оронд социализм зонхилон давамгайлж, хувийн өмч өчүүхэн хувийг эзэлж, хэний ч хөрөнгө мөнгө нь капитал болж чадахгүй учир капитализм сэргэж, улс орны социалист хөгжлийн замыг өөрчилж чадахгүй гэж үзэж байгаа байна.

“Гурван улаан туг”-ийн бодлого, “соёлын хувьсгал”-ын үед болон түүний дараах үед маогийнхан нь цэрэг дайны стратегийн ач холбогдолтой үйлдвэрүүд, түүнтэй холбогдол бүхий хүнд үйлдвэрийг онцгой анхаарч байжээ. Хятадын ард түмний шургуу хөдөлмөрийн ачаар тэдгээр үйлдвэр, аж ахуйн газрын бүтээгдэхүүний хэмжээ нэлээд нэмэгдэж, сүүлийн үед хөдөө аж ахуй, хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлд ахиц гарав. Хятадын албан ёсны мэдээгээр 1984 онд БНХАУ нь 400 сая тонн үр тариа хурааж, 760 сая тонн чулуун нүүрс, 114 сая тонн нефть олзворлосон, 351.4 миллиард киловат цаг цахилгаан гаргасан, 43.3 сая тонн болд хайлуулсан, 100 сая тонн цемент, 300 мянган автомашин, 1.6 сая өнгөт телевизор үйлдвэрлэсэн байна. Хятад улсад гол төлөв цэрэг-стратегийн зориулгатай атом, халуун цөмийн ба лазерийн эрчим хүчин гаргаж, электрон техник үйлдвэрлэж ашигладаг болжээ. Пуужингийн үйлдвэр барьж, хиймэл дагуул хөөргөдөг болж улмаар сансарт нисгэгч хөөргөх бэлтгэл хийж байгаа ажээ. БНХАУ 1984 оны байдлаар дэлхийн 128 оронтой дипломат харилцаатай, 174 улс, бүс нутагтай худалдаа, эдийн засгийн харилцаатай, 136 оронтой соёлын харилцаатай болжээ.

Гадаад улс төрийн бодлогын хувьд өнөөгийн Хятадын удирдлага нь АНУ зэрэг империалист гүрнүүд, хөрөнгөтөн ертөнцтэй харилцаа, холбоо, хамтын ажиллагааг улам улмаар бэхжүүлэх бодлого явуулж байна. 1979 онд Дэн Сяопин АНУ-д албан ёсны айлчлал хийснээс хойш Америк, Хятадын хооронд цэрэг-улс төрийн хамтын ажиллагаа тогтоох оролдлого нэн идэвхжив. 1983 онд ХКН-ын Төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобан Японд, 1982-1984 онд БНХАУ-ын төрийн зөвлөлийн ерөнхий сайд Чжао Цзыян Америк, Япон, Баруун Европын хөрөнгөтөн орнуудад айлчилж, орчин үеийн цэрэг дайны зэвсэг, техник-технологийн нууцуудыг худалдан авах, цэрэг-улс

төрийн талын харилцаа холбоог өргөтгөн бэхжүүлэх тухай ярилцсан юм. Сүүлийн жилүүдэд БНХАУ-д АНУ-ын ерөнхийлөгч Р.Рейган, Японы Ерөнхий сайд Я.Накасонэ, Английн ерөнхий сайд М.Тэтчер хатагтай, баруун Германы ерөнхийлөгч байсан К.Карстенс, Францын ерөнхийлөгч Ф.Меттеран, АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Ж.Шүльц, батлан хамгаалах яамны сайд К.Уайнбергер, Америкийн цэргийн жанжин штабуудын нэгдсэн зөвлөлийн дарга Ж.Весси нарын зэрэг империалист гүрнүүдийн төр, засгийн тэргүүн, цэрэг тагнуулын байгууллагын төлөөлөгчдийг урьж зочлуулан, цэрэг-стратегийн бодлогын асуудлуудыг хэлэлцэн тохиролцож байв. Хятадын удирдлага нь Японтой “XXI зууны Хятад, Японы залуучуудын найрамдлын холбоо” гэгчийг байгуулсан бөгөөд тэр нь хөрөнгөтөн ертөнц, империалист гүрнүүдтэй Хятадын ойртож байгаа явдал түр зуурын арга тактикийн асуудал төдий зүйл биш гэдгийг харуулав.

Хятадын удирдлага нь өөрийн улсыг социалист орон гэж ярьдаг боловч хөгжиж байгаа орнуудын тоонд оруулж, “гуравдагч ертөнцөд”, ялангуяа Африкт байр суурь, хүч нөлөөгөө бэхжүүлэхийг чухалчилж байна. Тэгэхдээ Афганистан зэрэг социалист чиг баримжааны улс орнуудад дайсагнаж, Пакистан, Чилийн зэрэг харгис дэглэмүүдийг империалистуудтай зэрэгцэн тэтгэж байна. Энэтхэг эвсэлд үл нэгдэгч орнуудын аюулгүй байдал, энх тайвны бодлогыг Бээжин дэмжихгүй байна.

Дэлхийн социалист системийг Бээжингийн удирдлага үгүйсгэхийг оролдож, ЗХУ зэрэг социалист орнуудын хувьд “ялгаварлан хандах” бодлого явуулсаар ирсэн билээ. Сүүлийн үед БНХАУ нь социалист орнуудтай худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёл, урлаг, спортын зэрэг зарим харилцааг өргөжүүлж эхэлсэн боловч цэрэг-улс төрийн талаар империалист гүрнүүд, капиталист системтэй сүлбэлдсэн хэвээр байна. Хятадын удирдлага нь Монгол, Афганистанаас Зөвлөлтийн цэргийг, Кампучаас вьетнамын цэргийг гаргахыг шаардаж байна. Социалист Вьетнамын хувьд Хятадын эрх баригчид шууд дайсагнаж, хорлон сүйтгэх явуулга үйлдэж, Энэтхэг-Хятадын хойг, Зүүн Өмнөд Азийн улс түмний аюулгүй байдал, даян дэлхийн энх тайвны үйл хэрэгт ноцтой бэрхшээл учруулсаар байв. Тэд “БНМАУ-ыг Хятадын хэсэг” байх ёстой гэсэн Мао Цзэдуны үхширмэл үзлээс албан ёсоор ангижран салж чадаагүй байна. БНХАУ-д хэвлэгдэж байгаа түүх, археологийн бүтээлүүдэд Монголыг “хэзээнээсээ Хятадын хэсэг” байсан гэж нотлохыг оролдлого хийсээр байна. Сүүлийн үед Бээжингийн удирдлагын зүгээс Монголын судлалын олон улсын төвийг өөрийн улсад шилжүүлэх зорилт тавьж байгаа нь санамсаргүй хэрэг биш юм.

1984 оны 11-р сард ЗХУ-ын сайд нарын зөвлөлийн 1-р орлогч дарга нөхөр И.В.Архипов БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, Зөвлөлт, Хятадын харилцааг сайжруулах тухай яриа хэлэлцээ хийсэн юм.

Энэ 1985 оноос эхлэн БНХАУ-ын засгийн газар нь ЗХУ-ыг социалист орон хэмээн урьдын адил албан ёсоор зөвшөөрөн хүлээж түүнтэй улс төрийн талаар хэвийн харилцааг сэргээж, нийт социалист орнуудтай өргөн харилцаа тогтоох тухай багагүй ярих болов. Зөвлөлт Хятадын харилцаа болон Хятад, социалист орнуудын харилцааг хэвийн байдалд оруулж сайжруулах явдал социализм, нийгмийн дэвшил, энх тайвны үйл хэрэгт чухал бөгөөд үүнийг социалист хамтын нөхөрлөлийн орнууд байнга анхаарч, түүний төлөө өөрсдөөсөө хамаарах бүхнийг хийж байна.

КРАТКИЙ ОБЗОР ИСТОРИИ КНР ПОСЛЕ- РЕВОЛЮЦИОННОГО ПЕРИОДА

(1949-1985)

Автор отмечает, что победа народной революции в Китае и образование КНР в 1949 году открыли перед китайским народом реальную возможность встать на путь социалистического развития.

В статье даются конкретные данные относительно блестящих успехов восстановительного периода и осуществления первого пятилетнего плана развития народного хозяйства и культуры страны, в результате чего была построена основа социализма.

Однако, вопреки установкам VIII съезда КПК (1956г). Мао Цзэдун и его последователи навязали партии и народу антисоциалистический, авантюристический курс так называемой “ненеральной линии”, “большого скачка”, “народных коммун” и “культурной революции”, которые в совокупности с ярим антисоветизмом ввергли страну в разрухи и бедствие, продолжавшиеся в течении двадцати с лишним лет.

После III пленума ЦК КПК, состоявшегося в конце 1978 г, и в особенности XII съезда партии (1982 г), новое руководство Китая, частично оказываясь от ряда явно обанкротившихся левозэкстремистских посылатов самого Мао, объявил курс более или менее прагматического подхода к проблемам развития страны и внешней политики. Нынешние китайские руководители в основном признают необходимость учета объективных закономерностей развития социалистического общества, планового развития народного хозяйства и культуры, материальной заинтересованности и распределения по труду, благодаря чему за последние годы в социально-экономическом развитии страны и в жизненном положении народных масс наблюдаются положительные сдвиги.

Тем не менее китайские руководители проводят политику построения “социализма с китайской”, “одной страны и двух систем”, поощрения частной собственности, “открытых дверей” для капиталистических государств. Во внешней политике они, правда, в отличие от маоцзэдуновского курса официально признали Советский Союз страной социализма, заявили о своем желании нормализовать отношения со странами социалистического содружества, развивать с ними торгово-экономические, научно-технические и культурные связи, а также о своей приверженности делу мира и безопасности народов.

В заключении статьи, как подчеркивает автор, хотя во внутренней и внешней политике КНР немало противоречивых аспектов в целом курс нынешнего китайского руководства заметно отличается более или менее реалистическим подходом к внутри- и внешнеполитическим проблемам страны от прежней маоцзэдуновской линии.